

“БИ СИ ЭЙЧ РЕСУРС” ХХК

“ГААЛИЙН ХЯНАЛТЫН  
БҮС БАЙГУУЛАХ”  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот  
2024 он

## АГУУЛГА

ОРШИЛ.....	1
НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. “Би Си Эйч Ресурс” ХХК-ийн үйл ажиллагаа.....	2
1.2. Төслийн байршил.....	3
1.3. Төслийн төлөвлөлт, хүчин чадал.....	3
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	5
2.1. Газрын гадарга, байр зүй.....	5
2.2. Цаг уур, уур амьсгал.....	5
2.3. Агаарын чанар, дуу чимээ.....	5
2.4. Геоморфологи.....	5
2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал.....	5
2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал.....	6
2.7. Амьтны аймаг.....	6
2.8. Гадаргын ус.....	6
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ.....	7
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	7
3.2. Нөхөн сэргээлт.....	8
3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах.....	8
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	8
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	8
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	8
3.7. Хог хаягдлын төлөвлөгөө.....	8
3.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	9
3.9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	10
3.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах.....	10
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
4.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө.....	15
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	15
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	16
4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	17
4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	19
4.9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	21
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах.....	23

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршил.....	3
-------------------------------	---

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн тусгай зөвшөөрлийн солбицол .....	3
Хүснэгт 2. Төсөлд ашиглах тоног төхөөрөмжийн жагсаалт .....	4
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө .....	15
Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	16
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	17
Хүснэгт 7. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	19
Хүснэгт 8. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө .....	21
Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө .....	23
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн .....	24

## ОРШИЛ

“БИ СИ ЭЙЧ РЕСУРС” ХХК-ийн “Гаалийн хяналтын бүс байгуулах”-ийн /цаашид “Төсөл” гэх/ зориулалттай төслийн газар нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт 10 га талбайг хамран оршиж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“БИ СИ ЭЙЧ РЕСУРС” ХХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал болон төслийн талбай орчимд хийгдсэн өмнөх шинжилгээний дүнг ашиглаж, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

## НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

<b>Төслийн нэр:</b>	“Гаалийн хяналтын бүс байгуулах”
<b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>	“БИ СИ ЭЙЧ РЕСУРС” ХХК
<b>Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:</b>	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо 4 улирлын цэцэрлэг 2-708 Утас:70110205
<b>Төслийн байршил, хаяг:</b>	Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум, Хулман нуур
<b>Нийт талбайн хэмжээ:</b>	10 га талбай
<b>Газар ашиглах зориулалт:</b>	Ачилт, буулгалтын зориулалтын бүхий талбай
<b>Газар ашиглах, эзэмших шийдвэр:</b>	MV-017480
<b>Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:</b>	9011720118
<b>Регистрийн дугаар:</b>	6275052
<b>Дэд бүтэц:</b>	Дулаан хангамж: Дулаан хангамжийг цахилгаанаар шийдсэн. Усан хангамж: Гүний худгаас цэвэр усны хэрэглээгээ зөөврийн аргаар ашигладаг. Хэрэглээнээс гарах бохир ус: Бохир ус хадгалах 8 тн, саванд хадгалдаг. Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Хяналтын талбайн цахилгааныг уурхайгаас хангана.

### 1.1. “Би Си Эйч Ресурс” ХХК-ийн үйл ажиллагаа


#### Төслийн зорилго

“Би Си Эйч Ресурс” ХХК нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших “Гаалийн хяналтын бүс байгуулах” төсөл Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр төслийн талбайд үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллах, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, төслийн талбайн нөхөн сэргээлтийг зохих стандартын дагуу хийж орон нутагт хүлээлгэн өгөхөд энэхүү төслийн зорилго оршино.

#### Төслийн байршил

Төслийн талбай нь Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн ашигт малтмал ашиглахыг зөвшөөрсөн MV-017480 тоот гэрчилгээтэй Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Хулман нуур” нэртэй газар орших 10 га бүхий ачилт буулгалтын зориулалт бүхий талбайтай.

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



**Зураг 1. Төслийн байршил**

*Хүснэгт 1. Төслийн тусгай зөвшөөрлийн солбицол*

№	WGS84		UTM84_N49	
	Уртраг	Өргөрөг	Y	X
1	110°3'48.21"	44 32 11.13	399957.375	5066933.913
2	110°3'40.82"	44 31 39.15	399957.778	5066891.914
3	110°3'54.24"	44 31 37.59	400044.280	5066867.067
4	110°4'1.64"	44 32 9.55	400331.700	5066885.269
5			400434.475	5067018.167
6			400258.530	5067198.563
7			400110.890	5067118.399
8			400132.487	5067072.652

## 1.2. Төслийн байршил

Төслийн талбай нь Засаг захиргааны хуваарилалтаар Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Өгөөмрийн Энгэр-1 нутаг дэвсгэрт 10 га талбайд байрлана. Улаанбаатар хотоос 760 км, Эрдэнэцагаан сумаас 50 км, Бичигтийн боомтоос 37 км орчим км зайтай байна.

## 1.3. Төслийн төлөвлөлт, хүчин чадал

Өгөөмрийн нүүрсний уурхайгаас нүүрс олборлон тээвэрлэн ачилт буулгалтын талбайд авчирч ангилан ялгалт /нүүрс дахь хүхрийн хэмжээгээр/ хийн гаалийн хяналт явуулж Бичигтийн боомтоор экспортлох үйл ажиллагаа явагдана.

## Технологи

Өгөөмрийн уурхай нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд нүүрс олборлон нүүрсэн дэх хүхрийн хэмжээгээр ялган буталж, нүүрс ачилт буулгалтын талбайд хураана. Гаалийн хяналтын үйл ажиллагааны хүрээнд бутлагдсан ачааг /нүүрс/ уурхайн агуулах дээрээс ачиж гаалийн бүрдүүлэлт хийн 300 м зайд байрлах гаалийн шалгах, пүүлэх хэсэгт хүргэнэ. Хяналтыг гаалийн хяналтын пүүгээр баталгаажуулж, 37 км-ийн зайд байрлах Бичигтийн боомтод хүргэнэ.

Хүснэгт 2. Төсөлд ашиглах тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Техник, тоног төхөөрөмж	Тоо ширхэг	Марк	Хүчин чадал
1	Дугуйт ачигч	2	Liugong 870H	4.2 м <sup>3</sup>
2	Дугуйт ачигч	1	LiuGong 855H	3 м <sup>3</sup>
3	Суудлын автомашин	1	Land cruiser 76	-
4	Авто пүү	1	SCS-200t 3.3*40м	-
5	Пүүний байр	1	Зөөврийн байр	200 тн
6	Хучигч нарын байр	1	Зөөврийн байр	40 тн
7	Мананцар үүсгэгч төхөөрөмж	1	/Spray stream 50L/	400-450 л/цаг
8	Автоцистерн	1	-	4 м <sup>3</sup>

## ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

### 2.1. Газрын гадарга, байр зүй

Монгол Дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг муж, Дарьгангын тэгш өндөрлөг талархаг тойрогт хамаарагддаг. Монгол орны геоморфологийн мужлалаар Дорноговийн цав толгодорхог мужид ордог. Хотгор гүдгэрийн хэв шинжээрээ цав толгодын хэв шинжтэй, цэрдийн галавын газарзүйн байрлалаар нүүрс хуримтлалын нутагт хамаарагддаг ба юра галавын үеийн галт уултай нутагт багтдаг.

### 2.2. Цаг уур, уур амьсгал

Төслийн талбай нь уур амьсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд Дорнод хэсгийн хүйтэн өвөлтэй хуурай эх газрын мужид хамаардаг. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 3.7°C бол зуны улиралд хамгийн их температур нь 60°, өвлийн улиралд -42°C хүрч байсан. Жилийн дундаж температур нь 1.7°C, хамгийн хүйтэн I сарын дундаж температур -21.7°C бол хамгийн дулаан сар болох 6-р сарын дундаж температур 21.7°C байдаг байна.

### 2.3. Агаарын чанар, дуу чимээ

Уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотойгоор машин механизмын хөдөлгөөнөөс бага зэрэг тоосжилт үүснэ. Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд агаарт дэгдэх зэргээр агаарын чанар, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дуу чимээний дундаж утгын түвшин Монгол улсын MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа ба дуу чимээний хамгийн их утга нь Монгол улсын MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй юм.

### 2.4. Геоморфологи

1975 онд М.Беспалов төслийн талбайн хойд хэсэгт Эрдэнэцагаан сумын нутагт Баянхайлааст, Нүхтийн ховор металлын хэд хэдэн илрэл дээр ерөнхий эрлийн ажил явуулж Ордовикийн настай занар, элсэн чулуулгийн зузаалаг, дунд-дээд зузаалаг, дунд-дээд Юрагийн бялхмал чулуулаг, доод Цэрдийн Цагаанцав формацын тунамал бялхмал зузаалаг, Неогений алаг өнгийн хурдас, доод Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас хэмээн тус тус ангилсан байна.

### 2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Монгол орны хөрсний ангиллаар хээрийн хөрсний бүлэгт багтах нимгэн хар хүрэн, ердийн хар хүрэн гэсэн 3 төрлийн хөрс зонхилон тархсан байна. Нимгэн хар хүрэн хөрс нь талбайн хойд хэсгийн уулархаг газрын энгэр орой олон гадаргын налуужилт ихтэй хажуу энгэр хэсгээр, ердийн хар хүрэн хөрс нь толгодын ар хажуугийн сүүдэрхэг газруудаар болон судаг, хөндий дагуу гадаргын чулуужилт багатай тэгшивтэр газруудад, ердийн хүрэн хөрс нь талбайн төв болон урд хэсгийн энгэр бэл газарт тус тус тархсан байна.



## 2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал

Талбайн хэмжээнд тал хээрийн ургамал зонхилох ба ургамлын бүтэц сайн, хээр талын ялзмаг сайтай хүрэн хөрстэй. Талархаг нугаараа хиаг, таана, монгол өвс, баглуур, шивээ, агь, шарилж, халгай, дагуур, сонгино, хайлаар буюу зэрлэг саримс, мангир, хөмүүл зэрэг ургамал ургана.

Төслийн талбай орчимд Хөндлөн хайлаасны ам, Тэрэгтийн ам зэрэг газруудад цөөн тооны хайлаас ургадаг бөгөөд Ачаа чулууны хад, Хадат ухаа, Бор-Өндөр толгой орчмоор бэлчээрийн нарийн өвс /хадлангийн нөөц/ ихээр ургана. Лхачинвандад уул түүний ойр орчимд эмийн ургамал ургадаг ба байгалийн нөөц газар юм.

## 2.7. Амьтны аймаг

Эрдэнэцагаан сум нь Монгол орны зэрлэг хөхтний газар зүйн мужлалаар хээрийн ба Баруун тойргуудад хамаарна. Энэ бүс нутаг нь Зүүн Азийн зарим зүйлийн (нохой, элбэнх, манж номин, дорнын сармаахай) зэргийн тархцын баруун хязгаар, мөн Төв Азийн уул, Говь, цөлийн олон зүйлийн (хар сүүлт, монгол тарвага, өөхлөг тагжиг даахай, шар чичүүл, дэлдэн зараа) тархцын зүүн, төв азийн уугуул зүйл цагаан зээрийн популяцийн байршил, тоо толгой, үржлийн үндсэн голомт нутаг юм.

Энэхүү тойрог 6 баг, 16 овог, 43 төрлийн 70 зүйл буюу Монгол орны зэрлэг хөхтний зүйлийн 50.7%-ийг эзэлдэг бол Эрдэнэцагаан сумын нутагт 6 багийн 9 овог 23 төрөл 27 зүйл хөхтөн амьтан нутаглаж байна.

## 2.8. Гадаргын ус

Сүхбаатар аймгийн нутгийн хойд болон зүүн хэсэг нь Номхон далайн ай савд бусад хэсэг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарахын зэрэгцээ гадаргын урсац сарних бүсэд оршдог. Иймд тус ай савын гадаргын усан сүлжээ нь хэмжээгээрээ нэлээд бага, тэдгээрийн гадаргын урсцын байгалийн горим нэлээд тогтворгүй, ихэвчлэн хатаж ширгэдэг. Аймгийн нутаг дэвсгэрт нийт 23 гол горхи, 11 рашаан, 382 булаг шанд, 1064 нуур, тойром бүртгэгдсэн байна.

## ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

### 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

#### Агаар

Агаарын чанарын гадаад орчны түгээмэл тархацтай бохирдуулах бодисыг хянахдаа “Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандартаар, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 стандарт”-аар, Ажлын байрны орчны бичил цаг уурын эрүүл ахуйн шаардлага, агаар дахь хорт бодисыг хянахдаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2023 стандартаар тодорхойлж төсөл хэрэгжүүлэгч эдгээрээс давах бохирдуулагч гаргахгүй байхад үндэслэгдэнэ.

- Тоосжилт бууруулах 8м-ээс багагүй өндөртэй зориулалтын хашааг талбайн хойд болон баруун талыг тойруулан барих
- Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар тогтоох (шороон замд 20-40 км/цаг-с хэтрүүлэхгүй), шороон замын маршрут гаргаж тэмдэгжүүлэх
- Тээврийн хэрэгслийг жил бор үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн завсар үйлчилгээг цаг тухайд нь хийх
- Ахуйн хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах

#### Гүний ус

Гүний усанд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Бохир ус тээвэрлэх байгууллагатай гэрээ байгуулан бохир усыг 70-80%-д дүүргэсэн үед соруулан зайлуулах

#### Хөрсөн бүрхэвч

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийх
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг үүсгэх шатанд нь ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хаягдлыг дахиврын үйлдвэрт тушаах, боловсруулах боломжгүй хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах
- Холбогдох журмын дагуу бохирын цооногийг тохижуулах
- Бохир усыг 70%-д дүүргэсэн үед соруулан зайлуулах
- Шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингээн авах, бохирдсон хөрсийг хусаж авах, саармагжуулах арга хэмжээ авах

- Сэлбэг хэрэгсэл, дугуйн хаягдлыг тусгаарласан хашлага бүхий тусгай талбайд хуримтлуулах, дугуй боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээлсний үндсэн дээр зайлуулах

### 3.2. Нөхөн сэргээлт

- Ойжуулалт ба зүлэгжүүлэлт хийх талбайн урьдчилан нөхцөлийг бүрдүүлэх
- Цаг уур, уур амьсгалын онцлогт тохирсон мод, сөөг, тарьж ургуулах (хайлаас, сухай, жигд, харгана, гүйлс)

### 3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

“Гаалийн хяналтын талбай байгуулах” төслийн үйл ажиллагаанд өртөх газар нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй үлдэх газарт хамаарахгүй тул биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгэх шаардлагатай төсөлд үл хамаарна.

### 3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

### 3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Талбайн орчимд түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлсийг хөндөх, түүнд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй тул БОМТ-нд түүх соёлыг хамгаалах арга хэмжээ тусгагдаагүй болно. Харин төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан хиригсүүр, археологи, палентлогийн зүйлс илрэх тохиолдолд соёлыг өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож, хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлнэ.

### 3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

- Аюулгүй тууз татах
- Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах саванд хадгалах
- Машин зогсоох талбайг хайргажуулан нягтруулах, бетондуулах
- Аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын сургалт хийх
- Аюултай хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих
- Ил уурхайн гадуур хамгаалалтын далан хийх, засаж сайжруулах
- Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх. Тэсэрч дэлбэрч болох материалын хадгалалт болон асгаралтыг хянаж байх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах

### 3.7. Хог хаягдлын төлөвлөгөө

Хог хаягдлын тухай 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн /шинэчилсэн найруулга/ хууль нь 8 бүлэг 43 зүйлээс тогтох ба тус хуулийн 1-р зүйлд заасан хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, ажилчдын хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах,

ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Бүх төрлийн ахуйн хатуу хог хаягдлыг үүсгэх шатанд нь ангилан ялгах хаягдлын савнуудыг төрөлжүүлэн байршуулах
- Ахуйн хатуу хог хаягдлын түр хадгалах цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийх
- Хог хаягдлын цэгийн доорх газрыг бетондох
- Ахуйн болон бүх төрлийн хог хаягдлыг шатааж устгахыг хориглох
- Ангилж ангилж ялгасан дахин боловсруулах боломжтой ахуйн хатуу хог хаягдлыг дахиврын үйлдвэрт тушаах, боловсруулах боломжгүй хэсгүүдийг зөвшөөрөгдсөн төвлөрсөн хогийн цэгт зайлуулах
- Шингэн хаягдал тээвэрлэн зайлуулах гэрээт байгууллагатай гэрээ байгуулан аль болох богино хугацаанд хаягдлыг зайлуулах
- Техникийн шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингэн галын аюулгүй нөхцөлд ариутгах, эсвэл дарж булах байдлаар цэвэрлэх, саармагжуулах
- Машин техникийн засвар үйлчилгээний үед гарах сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг хаягдал дугуй боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээлсний үндсэн дээр тогтмол зайлуулж байх
- Машин механизм ашигласан тос, тосолгооны материалын сав баглаа боодол, мод, хуванцар эд материал, ашигласан батгрей, картон болон хуванцар, баглаа боодлын сав, нөөцлүүрт байгаа хаягдал, ашигласан тосны шүүр, аккумулятор зэрэг хаягдлыг дахин ашиглуулахаар нийлүүлэгчид өгөх ба дахин боловсруулагдахгүй, ашиглагдахгүй хог (органик хаягдал) хаягдлуудыг зөвшөөрөл бүхий орон нутгаас заасан цэгт зөөвөрлөн хоргүйжүүлж устгах, эсвэл аюултай хог хаягдал устгах зайлуулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж шилжүүлэх

### **3.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр**

#### **Агаарын чанар**

- Ачих, буулгах хэсэг, зам, ажилчдын тосгоны орчноос
- Төслийн талбайгаас 800м орчим зайд байрлах ажилчдын орон сууцны орчмоос

#### **Хөрсөн бүрхэвч**

- Хогийн цэгийн орчмоос
- Ачих буулгах хэсэг, зам, машин засварын газрын орчмоос
- Сул чөлөөтэй талбайгаас

#### **Усан орчин**

- Гүний худгийн уснаас

### 3.9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

- Ажлын байрны шинжилгээг хийлгэж хяналт тавьж байх
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх
- Сургалтуудыг үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон дараа шат дараатайгаар тогтмол явуулах
- Аливаа болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах, ослын үед ажилчдыг зөв зохион байгуулж удирдан чиглүүлэх, эмх замбраагүй байдлаас урьдчилан сэргийлэх
- ТЖБОМТ-г өмнөх оны 12-р сард багтаан БОАЖЯам-р батлуулж, уг ТЖБОМТ-нд тусгасан төлөвлөгөөт ажлуудаа тухайн ондоо хийж гүйцэтгэсний дараа биелэлтийн тайланг боловсруулан 11-р сард багтаан орон нутгаас томилогдон ажлын хэсгээр холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд нь дүгнүүлэх
- Үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, гэрээ, дүгнэлтүүд (ус ашиглах гэрээ, ус ашиглах зөвшөөрөл, усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт, ажлын байрны дүгнэлт, галын аюулгүй байдлын дүгнэлт, хатуу болон шингэн хаягдал тээвэрлэх гэрээ)-ийг үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох газраар гаргуулах, төлбөр тооцоог тогтсон хугацаанд хийх

### 3.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

- Санал, хүсэлт хүлээн авч төсөлтэй холбогдох гомдлыг барагдуулах
- ТЖБОМТ-г батлуулж, биелэлтийн тайлангаа дүгнүүлэх
- Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах
- Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон 2012 оны 05 дугаар сарын 17 өдрийн /Шинэчилсэн найруулга/ “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа “Гаалийн хяналтын бүс байгуулах” үйл ажиллагааны явцад байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлсны үндсэн дээр тус төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүрээлэн буй орчинд, хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга зам, анхаарвал зохих асуудлын талаар нарийвчлан төлөвлөлөө. Үүнд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр заавал авч хэрэгжүүлж байх арга хэмжээ, агаар, хөрс, ус зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусгаж оруулсан болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгах шаардлагатай байдаг.

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

*Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Агаарын чанар</b>									
1	Нүүрс тээвэрлэх, ачих, буулгах зэрэг төслийн талбай дээр хийгдэх ажлын үед тоос, тоосжилт үүсэх	Тоосжилт бууруулах 8м-ээс багагүй өндөртэй зориулалтын хашааг талбайн хойд болон баруун талыг тойруулан барих	Талбайн хойд болон баруун талд 1300м урт	585.0			2024 он	Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS4585:2016 Гадна агаарын ЗДХ)	
2		Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар тогтоох (шороон замд 20-40 км/цаг-с хэтрүүлэхгүй), шороон замын маршрут гаргаж тэмдэгжүүлэх	Эзэмшил талбайн дундах зам, нүүрс ачих буулгах талбай	Ширхэг	100.0	5	500.0	2024 он	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4597:2014
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс хорт хий ялгарах	Тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх	Тээврийн хэрэгслүүд	ҮА-ны зардлаар			2024 он	<ul style="list-style-type: none"> <li>“Бензин хөдөлгүүртэй автомашин утааны найрлага дах хорт бодисын ЗДХ ба хэмжих арга” MNS5013:2009</li> <li>“Дизель хөдөлгүүртэй автомашин утааны тогторжилтын ЗДХ ба хэмжих арга” MNS5014:2009</li> </ul>	

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4	Ахуйн хог хаягдлаар агаар бохирдох	Ахуйн хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах	Хаягдлын цэгийг орчимд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын тухай хууль, 2017 он</li> <li>• Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS5344:2011</li> </ul>
<b>Усан орчин</b>						
5	Бохирын цооногоор дамжин гүний ус бохирдох	Бохир ус тээвэрлэх байгууллагатай гэрээ байгуулан бохир усыг 70-80%-д дүүргэсэн үед соруулан зайлуулах	Бохирын цооногийн орчимд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын тухай хууль, 2017 он</li> <li>• Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тогтоох журам. БОАЖСайд, ЭМСайдын хамтарсан 2018.04.05-ны А/82/128 тоот тушаал</li> </ul>
<b>Хөрсөн бүрхэвч</b>						
6	Хог хаягдлаар газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдох	Хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийх Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг үүсгэх шатанд нь ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хаягдлыг дахиврын үйлдвэрт	Төслийн хаягдлын цэг орчимд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын тухай хууль, 2017 он</li> <li>• Хаягдлын цэгийн стандарт MNS BS5906:2015</li> <li>• Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS5344:2011</li> </ul>



**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		тушаах, боловсруулах боломжгүй хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах				
7	Бохирын цооногоор дамжин хөрс бохирдох	Холбогдох журмын дагуу бохирын цооногийг тохижуулах Бохир усыг 70%-д дүүргэсэн үед соруулан зайлуулах	Шингэн хаягдлын цэгийн орчим	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын тухай хууль, 2017 он</li> <li>• Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж, тохижуулах журам БОАЖСайд, ЭМСайдын хамтарсан 2018.04.05-ны А/82/128 тоот тушаал</li> </ul>
8	Тос тосолгооны материалын хаягдлаар хөрс бохирдох	Шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингээн авах, бохирдсон хөрсийг хусаж авах, саармагжуулах арга хэмжээ авах	Автомашины зогсоол, нүүрс ачих буулгах талбайн орчинд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS3297:1991</li> <li>• Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2008</li> <li>• Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл MNS3985:1987</li> </ul>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>				<b>1,085.0 МЯН.ТӨГ</b>		

#### 4.2. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Биологийн нөхөн сэргээлт</b>								
1	• Хашааг тойруулан хойд болон баруун талаар 2 эгнээ ойн зурвас байгуулах • 1 га талбайг зүлэгжүүлэх	Ойжуулалт ба зүлэгжүүлэлт хийх талбайн урьдчилан нөхцөлийг бүрдүүлэх			200.0	400.0	2024 он	“Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS5914:2008
2		Цаг уур, уур амьсгалын онцлогт тохирсон мод, сөөг, тарьж ургуулах (хайлаас, сухай, жигд, харгана, гүйлс)	• 850 м тууш талбайд 560 ш суулгац • 1 га талбайд		200.0	400.0	2024 он	“Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS5918:2008
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>					<b>800.0 МЯН.ТӨГ</b>			

#### 4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Гаалийн хяналтын талбай байгуулах” төслийн үйл ажиллагаанд өртөх газар нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй үлдэх газарт хамаарахгүй тул биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгэх шаардлагатай төсөлд үл хамаарна.

#### 4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

#### 4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Талбайн орчимд түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлсийг хөндөх, түүнд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй тул БОМТ-нд түүх соёлыг хамгаалах арга хэмжээ тусгагдаагүй болно. Харин төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан хиригсүүр, археологи, палентлогийн зүйлс илрэх тохиолдолд соёлыг өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож, хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлнэ.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Уурхайн ажлын явц дахь болзошгүй	Аюулгүй тууз татах	Уурхайн орчинд	100м	10.0	1,000.0	2024 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр/	
2	Шатах тослох материал шатах эрсдэлээс сэргийлэх	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах саванд хадгалах		ҮА-ны зардлаар			2024 он	Газрын тосны бүтээгдэхүүний тухай /2005 оны 7 дугаар сарын 1-ны өдөр/	
3	Шатах тослох материалын асгаралт	Машин зогсоох талбайг хайргажуулан нягтруулах, бетондуулах		Хөрсний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан			2024 он		
4	Аюултай хог хаягдлын хадгалалт,	Аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын сургалт хийх	Уурхайн болон кемп орчин	ҮА-ны зардлаар			2024 он	Химийн хорт болон аюултай бодисын тухай /2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр/	
5	тээвэрлэлтийн явцад учрах эрсдэл	Аюултай хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих		1	50.0	50.0	2024 он		
6	Газрын хөрс, барилга байгууламж эвдрэх, уурхайн үеийн усанд автах	Ил уурхайн гадуур хамгаалалтын далан хийх, засаж сайжруулах		ҮА-ны зардлаар			2024 он		“Гамшгаас хамгаалах тухай” /Шинэчилсэн найруулга/ 2017 оны 02 сарын 02 өдөр
7	Хээрийн түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх. Тэсэрч дэлбэрч болох материалын хадгалалт болон асгаралтыг хянаж байх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах	Уурхай орчмын талбай болон уурхайн бүс	ҮА-ны зардлаар			2024 он	“Ой хээрийн түймэр унтраахад оролцуулах тухай” 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдөр Дугаар-09	
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>							<b>1,050.0 МЯН.ТӨГ</b>		

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг ангилах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мөн.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтжуулах эрх зүйн баримт бичиг	
1	Орчны бохирдол үүсгэх	Бүх төрлийн ахуйн хатуу хог хаягдлыг үүсгэх шатанд нь ангилан ялгах хаягдлын савнуудыг төрөлжүүлэн байршуулах	Ажилчдын сууц, оффис, автомашины засварын газрын орчимд	Ширхэг	100.0	5	500.0	2024 он	“Хог хаягдлын тухай хууль”, 2017 он “Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” MNS5344:2011 “Барилга доторх хог хаягдлын менежмент-Ашиглалтын дүрэм” MNS BE5906:2018	
2		Ахуйн хатуу хог хаягдлын түр хадгалах цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийх Хог хаягдлын цэгийн доорх газрыг бетондох	Хог хаягдлын цэгийн хүрээнд	-	1,000.0	-	1,000.0			
3		Ахуйн болон бүх төрлийн хог хаягдлыг шатааж устгахыг хориглох	ҮА-ны зардлаар							
4		Ангилж ангилж ялгасан дахин боловсруулах боломжтой ахуйн хатуу хог хаягдлыг дахиврын үйлдвэрт тушаах, боловсруулах боломжгүй хэсгүүдийг зөвшөөрөгдсөн төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Сард 1 удаа	Удаа	35.0	5	175.0			

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

5	Шингэн хаягдлаар хөрс, газрын доорх ус бохирдол	Шингэн хаягдал тээвэрлэн зайлуулах гэрээт байгууллагатай гэрээ байгуулан аль болох богино хугацаанд хаягдлыг зайлуулах	Хог хаягдлын цэгийн хүрээнд	Удаа	35.0	5	175.0	“Хог хаягдлын тухай хууль”, 2017 он “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлаж тохижуулах журам. БОАЖСайд, ЭМСайдын хамтарсан 2018.04.05-ны А/82/128 тоот тушаал
6	Шатахуун, тос тосолгооны материалаар хаягдлаар хөрс, газрын доорх ус бохирдох	Техникийн шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингээн галын аюулгүй нөхцөлд ариутгах, эсвэл дарж булах байдлаар цэвэрлэх, саармагжуулах	Төслийн үйл ажиллагааны үед гарах тусгай ангиллын хаягдлын хүрээнд	Асгарсан тохиолдолд нэн даруй			Хог хаягдлын тухай хууль, 2017 он	
7		Машин техникийн засвар үйлчилгээний үед гарах сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг хаягдал дугуй боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээлсний үндсэн дээр тогтмол зайлуулж байх		Сэлбэг хэрэгсэл, дугуй, тос тосолгооны материалын хаягдал гарсан тохиолдолд зайлуулах зардлыг үйл ажиллагааны зардалд оруулан төлөвлөх				
8		Машин механизм ашигласан тос, тосолгооны материалын сав баглаа боодол, мод, хуванцар эд материал, ашигласан батррей, картон болон хуванцар, баглаа боодлын сав, нөөцлүүрт байгаа хаягдал, ашигласан тосны шүүр, аккумулятор зэрэг хаягдлыг дахин ашиглуулахаар нийлүүлэгчид өгөх ба дахин боловсруулагдахгүй, ашиглагдахгүй хог (органик хаягдал) хаягдлуудыг зөвшөөрөл						

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		бүхий орон нутгаас заасан цэгт зөөвөрлөн хоргүйжүүлж устгах, эсвэл аюултай хог хаягдал устгах зайлуулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж шилжүүлэх					
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>				<b>1,850.0 МЯН.ТӨГ</b>			

**4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр**

*Хүснэгт 7. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>								
1	Том болон нарийн ширхэглэгт тоосонцор /PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> /	Ачих, буулгах хэсэг, зам, ажилчдын тосгоны орчноос	2024 онд 1 удаа	3 цэгт	75.0	150.0	-	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885:2008/ (Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ)
2		Төслийн талбайгаас 800м орчим зайд байрлах ажилчдын орон сууцны орчмоос		1 цэгт			-	
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
3	Бичил биетний тоо (1гр-д) Колититр Cl.perferringens титр	Хогийн цэгийн орчмоос	2024 онд 1 удаа	1 дээж	24.0	24.0	-	<ul style="list-style-type: none"> <li>• Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд /MNS 3298:1991/</li> <li>• Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам /MNS 2305:1995/</li> <li>• Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис,</li> </ul>
4	Хүнд металлууд /Pb, Cd, Cr, Ni, Zn/	Ачих буулгах хэсэг, зам, машин засварын газрын орчмоос	2024 онд 1 удаа	1 дээж	50.0	50.0	-	
5	Үржил шим тодорхойлох	Сул чөлөөтэй талбайгаас	2024 онд 1 удаа	1 дээж	25.0	25.0	-	

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

								элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. /MNS 5850:2008/
<b>Усан орчин</b>								
6	Усны химийн ерөнхий шинжилгээ	Гүний худгийн уснаас	2024 онд 1 удаа	1 дээж	60.0	60.0	-	<ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчин. Усны чанар. Дээж авах. 5-р хэсэг: ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэхэд уснаас дээж авах заавар /MNS ISO 5667-5:2001/</li> <li>• Усны чанар-Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж /MNS ISO 5667-11:2000/</li> <li>• Ундны усны чанарын стандарт /MNS 0900:2005/</li> </ul>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>					<b>309.0 МЯН.ТӨГ</b>			

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.9. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 8. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			10 сар	11 сар	12 сар		
1	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын байрны шинжилгээг хийлгэж хяналт тавьж байх</li> <li>Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх</li> </ul>	Зардал хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан. Дотоод төлөвлөлтөөр (үнэлгээ хийх байгууллагад хандах)	*			Байгаль орчны мэргэжилтэн	Ажлын орчны температур, чимээ шуугиан, тоосжилт зэрэг үзүүлэлтүүд стандарт нормын хэмжээнээс өөр байх нөхцөлд ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.
2		Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах (30 хүн)		*			
3	Сургалтуудыг үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон дараа шат дараатайгаар тогтмол явуулах	100.0	*	*	*	ХАБЭА	Ажилчдад ХХАА, үйлдвэрийн ослын үед анхан шатны тусламж үзүүлэх, гал түймрийн аюул болон бусад гамшигт үзэгдлийн үед авах арга хэмжээ, байгаль хамгаалах, хог хаягдлаа ил задгай хаяхгүй байх, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, ялангуяа усны зохисгүй хэрэглээг багасгах гэх мэт сэдвүүдийн хүрээнд ажилчдад зориулсан төлөвлөгөөт сургалт, сурталчилгааг тогтмол явуулж хэвшүүлэх, ингэснээр ажилчдад ажлын байрны орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй ажиллах амьдрах зөв хандлагыг төлөвшүүлэх
4	Аливаа болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг	-	*	*	*	ХАБЭА	Аюул ослоос урьдчилан сэргийлэх



**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	хангах, ослын үед ажилчдыг зөв зохион байгуулж удирдан чиглүүлэх, эмх замбраагүй байдлаас урьдчилан сэргийлэх						
5	ТЖБОМТ-г өмнөх оны 12-р сард багтаан БОАЖЯ-м-р батлуулж, уг ТЖБОМТ-нд тусгасан төлөвлөгөөт ажлуудаа тухайн ондоо хийж гүйцэтгэсний дараа биелэлтийн тайланг боловсруулан 11-р сард багтаан орон нутгаас томилогдон ажлын хэсгээр холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд нь дүгнүүлэх	500.0	*			Байгаль орчны мэргэжилтэн	Хууль эрх зүйн орчинд
6	Үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, гэрээ, дүгнэлтүүд (ус ашиглах гэрээ, ус ашиглах зөвшөөрөл, усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт, ажлын байрны дүгнэлт, галын аюулгүй байдлын дүгнэлт, хатуу болон шингэн хаягдал тээвэрлэх гэрээ)-ийг үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох газраар гаргуулах, төлбөр тооцоог тогтсон хугацаанд хийх		*	*	*	Байгаль орчны мэргэжилтэн	Хууль эрх зүйн орчинд
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>						<b>600.0 МЯН.ТӨГ</b>	

**4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах**

*Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө*

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал,төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Иргэд олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд	Санал, хүсэлт хүлээн авч төсөлтэй холбогдох гомдлыг барагдуулах	Байгаль орчны талаар тавьсан санал гомдолтой холбогдох бүхий бүх төрлийн мэдээлэл	2024 он	-	Байгаль орчны мэргэжилтэн	5-р багийн ИНХ-ын танхимд
2	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, БОАЖЯ	ТЖБОМТ-г батлуулж, биелэлтийн тайлангаа дүгнүүлэх	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Жилийн эцсээр 1 удаа	-	Байгаль орчны мэргэжилтэн	-
3	Эрдэнэцагаан сумын Засаг Дарга	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа	-	Байгаль орчны мэргэжилтэн	-
4	5-р баг (Зүүнбаян)-ийн ИНХ	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа	-	Байгаль орчны мэргэжилтэн	5-р багийн ИНХ-ын танхимд

**Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй  
“Гаалийн хяналтын бүс байгуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн*

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэх хугацаа	Нийт дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төг	2024 он	1,085.0
2	Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө	төг		800.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг		-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ			-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө			-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төг		1,050.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	төг		1,850.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төг		309.0
9	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	төг		600.0
10	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	төг		-
<b>НИЙТ ДҮН</b>				<b>5,694.0 МЯН.ТӨГ</b>